

Банкны нэр:

**БАНКНЫ ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ЗАГВАР**

**Зарчим 1: ТУЗ-ийн үүрэг хариуцлага**

**“ТУЗ нь банкны бизнес стратеги болон зорилт, банкны соёл, засаглал буюу ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагын хэм хэмжээг тодорхойлох, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, эрсдэл, хөрвөх чадварын талаар баримтлах бодлогыг боловсруулж батлах, тэдгээрт тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх зэрэг банкны эрх ашгийг хамгаалж, бизнесийн зорилтын биелэлтийг хангах үүргийг хүлээнэ.”**

№	Асуулт	Банкны үнэлгээ	Хянан шалгагчийн үнэлгээ	Тайлбар /тийм, хагас биелсэн хариултад тайлбар ирүүлэх /
		Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	Хангасан-2, Дунд-1, Хангаагүй-0	
1	Журмын 2.1-д заасан ТУЗ нь хадгаламж эзэмшигч болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах ба хувьцааны тоо хэмжээнээс үл хамааран нийт хувьцаа эзэмшигчдэд шударга, тэгш байдлаар хандаж байгаа эсэх?	2	2	
2	ТУЗ нь журмын 2.3 болон 2.4-д заасан бодлогын баримт бичгүүдийг баталсан уу?	2	2	
3	Журмын 2.5-д заасан ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлын мэдээллийг ТУЗ-ийн хурлаас 5 хоногийн өмнө авсан эсэх?	2	2	

4	ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн шийдвэр эсвэл арга хэмжээтэй санал нийлэхгүй байгаа талаар санал, байр сууриа бичгээр илэрхийлж байсан уу? Энэ талаар хурлын тэмдэглэлд тусгахыг шаардаж байсан уу? Ийм тохиолдол хамгийн сүүлд хэзээ болсон талаар танилцуулна уу?	2	2	
5	Сонирхлын зөрчлийн талаарх бодлого, журам болон ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын сонирхлын зөрчлийн судалгаа, мэдээллийн санг бүрдүүлнэ. Журмын 2.4.5-д заасан хэрэгжилтийг танилцуулна уу?	2	2	
6	Зөвхөн ТУЗ-ийн хараат бус гишүүд хуралддаг уу? Мөн ТУЗ-ийн дарга болон бусад хороодын дарга нар хурлаас өмнө зөвлөлдөх тохиолдол гарж байсан уу?	2	2	
7	ТУЗ болон гүйцэтгэх удирдлага ESG буюу "Environment" (Байгаль орчин), "Society" (Нийгэм), "Governance" (Засаглал) үзүүлэлтүүдийг бизнесийн шийдвэр гаргалтад хэрхэн тусгаж, үр дүнг тогтмол хянадаг вэ?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>14</b>	<b>14</b>	
<b>Зарчим 2. ТУЗ-ийн мэргэшсэн байдал, бүрэлдэхүүн</b> <b>"ТУЗ-ийн гишүүд нь банкийг удирдан зохион байгуулах түвшний мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай бөгөөд хяналт, засаглалын үүргээ бүрэн ойлгож, банкны үйл ажиллагаанд бодитой дүгнэлт хийх чадвартай байх ёстой."</b>				
1	Журмын 2.2 заасны дагуу ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг мэргэжлийн болон ашиг сонирхлын тэнцвэрт байдлыг хангаж бүрдүүлэх ба дийлэнх олонхыг хараат бус гишүүнээр бүрдүүлсэн үү? /Аль нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийг төлөөлж ажиллаж байгаа талаар гишүүн тус бүрээр тайлбарлана уу?/	2	2	

2	ТУЗ-ийн хурлыг банкны дүрэмд заасан тооноос доошгүй удаа хуралдуулж, ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг дэлгэрэнгүй баталгаажуулан, хэлэлцсэн асуудалтай холбоотой баримт материал, гаргасан шийдвэрийн хамт тогтоосон хугацаанд Монголбанкинд хүргүүлсэн эсэх?	2	2	
3	ТУЗ-ийн гишүүнд шинээр нэр дэвшүүлэх, сонгох, банкны стратеги боловсруулах зэрэг засаглалын гол шийдвэрүүдийг гаргахдаа хувьцаа эзэмшигчдийн идэвхтэй оролцоог хангаж, кумулятив аргачлал ашиглан санал хураасан эсэх?	2	2	
4	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн санал болон хувьцаа эзэмшигчдээс өгсөн зарчмын зөрүүтэй, эсэргүүцсэн саналыг хэлэлцэж, шийдвэрлэдэг эсэх, энэ талаар мэдээллийн сан үүсгэсэн эсэх?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>8</b>	<b>8</b>	
<b>Зарчим 3. ТУЗ-ийн бүтэц, үйл ажиллагааны зарчим:</b> <b>“ТУЗ нь банкны үйл ажиллагааны онцлогт тохирсон засаглалын бүтцийг тодорхойлж, дагаж мөрдөх арга хэрэгслийг бий болгож, үр дүнтэй хяналт тавих үүрэгтэй ба ТУЗ-ийн дэргэдэх аудитын, эрсдэлийн, цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороодыг байгуулна.”</b>				
1	ТУЗ-ийн дарга нь өөр хороог даргалдаггүй мөн өөр хороонд харьяалагдахгүй зөвхөн ТУЗ-ийн даргын үүрэгтэй хараат бус гишүүн мөн үү?	2	2	
2	Журмын 2.7-д заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнийг 3 жилийн хугацаатай томилогдсон уу? Хэрвээ улируулан томилогдсон бол мөн хугацаагаар томилсон эсэх?	2	2	
3	ТУЗ-ийн гишүүн улируулан томилогдсон бол журмын 2.8-д заасан шаардлагыг харгалзаж үзсэн эсэх?	2	2	

4	Журмын 2.9-д заасны дагуу Комплайнсын захирал, Эрсдэл хариуцсан захирал /CRO/, Банкны тухай хуулийн 31.3.6-д	2	2	
<b>Нэр дэвшүүлэх хороо</b>				
5	Нэр дэвшүүлэх хорооны дарга нь хараат бус гишүүн мөн үү?	2	2	
6	Нэр дэвшүүлэх хороо нь журмын 2.13-д заасан бүрэн эрх, хэрэгжилт, хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байна вэ?	2	2	
<b>Цалин урамшууллын хороо</b>				
7	Цалин, урамшууллын хорооны дарга нь хараат бус гишүүн мөн үү?	2	2	
8	Цалин урамшууллын хороо нь журмын 2.14-д заасан бүрэн эрх, хэрэгжилт, хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байна вэ?	2	2	
<b>Аудитын хороо</b>				
9	Аудитын хорооны дарга нь бусад хороонд харьяалагдахгүй хараат бус гишүүн мөн үү? Тус хорооны бүх гишүүдийг хараат бус гишүүдээр бүрдүүлсэн үү?	2	2	
10	Аудитын хороо нь журмын 2.15-д заасан бүрэн эрх, хэрэгжилт, хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байна вэ?	2	2	
<b>Эрсдэлийн удирдлагын хороо</b>				
11	Эрсдэлийн удирдлагын хорооны дарга нь бусад хороонд харьяалагдахгүй хараат бус гишүүн мөн үү? Тус хорооны бүх гишүүдийг хараат бус гишүүнээр бүрдүүлсэн үү?	2	2	

12	Эрсдэлийн удирдлагын хороо нь журмын 2.16-д заасан бүрэн эрх, хэрэгжилт, хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байна вэ?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>24</b>	<b>24</b>	

**Зарчим 4. Гүйцэтгэх удирдлага:**

**Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу банкны үйл ажиллагааг бизнесийн стратеги, эрсдэлийн аппетит болон цалин урамшууллын бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.**

1	Гүйцэтгэх удирдлага нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 34 дүгээр зүйлд тус тус заасныг шаардлагуудыг хэрхэн биелүүлж байгаа вэ?	2	2	
2	Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг хэрхэн хянаж, урамшуулал олгодог вэ? Гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшууллийн бүтэц нь сайн гүйцэтгэл, эрсдэлийн удирдлагын зорилтуудтай нийцэж байна уу? Түүнийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлсэн эсэх?	2	2	
3	Журмын 3.1.2-д заасан мэдээллийг тогтмол тайлагнаж байгаа эсэх?	2	2	
4	Журмын 3.2-д заасан шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар зөвшөөрөгдсөн эсэх?	2	2	
5	Гүйцэтгэх удирдлага нь банкны бизнесийн гүйцэтгэл, санхүүгийн нөхцөл байдал, эрсдэлийн хязгаар давсан болон комплайнс, дотоод аудитаар илэрсэн алдаа дутагдлын талаар ТУЗ-д хэн, хэрхэн тайлагнадаг вэ?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>10</b>	<b>10</b>	

**Зарчим 5. Банкны нэгдлийн засаглал:**

**"Банкны нэгдлийн толгой компани нь нэгдлийн оролцогчдын засаглал, бизнесийн болон эрсдэлийн бүтцийг тодорхойлж, банкны ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь нэгдлийн бүтэц, үүсэж болох эрсдэлийн талаар мэдээлэлтэй байна."**

1	ТУЗ, Гүйцэтгэх удирдлага нь банкны нэгдлийн бусад этгээдийн үйл ажиллагаа болон үүсэж болох эрсдэлийн талаар мэдээлэлтэй байдаг уу?	2	2	
2	Банкны нэгдэл дэх сонирхлын зөрчлийг хэрхэн тодорхойлж, шийдвэрлэдэг вэ?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>4</b>	<b>4</b>	
<b>Зарчим 6. Эрсдэлийн удирдлага</b> <b>"Эрсдэл хариуцсан захирал /CRO/ нь Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаа явуулж, ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороонд шууд тайлагнахыг зөвлөдөг."</b>				
1	Журмын 4.3-д заасан Эрсдэлийн удирдлагын нэгж нь банкны бизнесийн үйл ажиллагаа, ашиг олох бүтцээс тусдаа байдаг уу?	2	2	
2	Журмын 4.4-д заасан эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаа нь ямар бүтцээс бүрддэг, хэрхэн тодорхойлж баталдаг, ямар давтамжтай хянадаг зэргийг нэг бүрчлэн тайлбарлана уу?	2	2	
3	Банк нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийн тодорхойлж, удирдах стратеги, бодлого боловсруулсан уу?	2	2	
4	CRO нь үйл ажиллагаа, шийдвэрээ ТУЗ-ийн Эрсдэлийн хороонд шууд тайлагнадаг уу? Эрсдэлийн хороотой жилд хэдэн удаа уулздаг вэ?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>8</b>	<b>8</b>	

**Зарчим 7. Эрсдэлийг үнэлж, хянах**

**"Банк нь банкны хэмжээнд болон нэгжийн түвшинд эрсдэлээ тодорхойлж, хянадаг байх шаардлагатай бөгөөд эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцоо нь гадаад орчны нөлөө болон эдийн засгийн өөрчлөлт дахь банкны эрсдэлийн төлөвийг хянадаг байх шаардлагатай."**

1	Банкны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, мониторинг хийх, хянах аргачлал, давтамж, оролцогчдыг танилцуулна уу. Салбар, нэгжийн зүгээс хамгийн сүүлд гаргасан эрсдэлийн сэрэмжлүүлгийн тухай танилцуулна уу.	2	2	
2	Шинэ бүтээгдэхүүнийг хэрхэн хөгжүүлдэг вэ? Шинэ бүтээгдэхүүний хороо байдаг уу? Ямар бодлого, журмаар зохицуулагддаг вэ? Шинэ бүтээгдэхүүнийг баталдаг эрх бүхий этгээд нь хэн бэ? Хүү, хугацаа зэрэг зээлийн бүтээгдэхүүний нөхцөлийг хэрхэн тогтоодог вэ?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>4</b>	<b>4</b>	

**Зарчим 8. Эрсдэлийн мэдээлэл солилцоо**

**"Үр дүнтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь банкны хэмжээнд болон ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад тайлагнах найдвартай харилцааг шаарддаг."**

1	Банкны мэдээллийн технологийн дэд бүтэц нь мэдээллийн иж бүрэн, найдвартай, тасралтгүй байдлыг хангаж чаддаг уу? Банкны зүгээс эрсдэлийн аппетитыг тооцоолоход шаардлагатай мэдээллээр тасралтгүй хангагдаж чадаж байна уу? ТУЗ-д тайлагнах, мэдээлэх зохицуулалтыг танилцуулна уу. ТУЗ-д банкны эрсдэлийн ерөнхий мэдээлэл, стресс тестийн үр дүн болон гадаад орчны мэдээллийг танилцуулдаг уу?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>2</b>	<b>2</b>	

**Зарчим 9. Комплайнс буюу Нийцлийн үйл ажиллагаа**

1	Комплайнсийн бодлогыг боловсруулж, баталсан үе шатуудыг танилцуулна уу. Комплайнстай холбоотой гарсан зөрчлийн талаар тайлагнадаг уу?	2	2	
2	Журмын 5.3-д заасны дагуу комплайнсийн нэгж нь хууль, тогтоомжийн өөрчлөлт, хэрэгжилтийн талаар тайлагнахаас гадна ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг хийдэг эсэх?	2	2	
3	Тухайн жилд хэдэн сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлсэн бэ?	2	2	
4	Шүгэл үлээхтэй холбоотой харилцааг зохицуулсан бодлогын баримт бичгийг баталсан уу? Шүгэл үлээгчийг хэрхэн нууцалж, хамгаалдаг вэ? Хамгийн сүүлд шүгэл үлээсэн тохиолдлыг танилцуулна уу?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>8</b>	<b>8</b>	
<b>Зарчим 10. Дотоод аудит ба хөндлөнгийн аудит</b> <b>“Дотоод аудит нь гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар ТУЗ-д аливаа зөрчил мэдээллийг тайлагнах ба ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагыг банкны урт хугацааны тогтвортой байдлыг хангах, үр нөлөөтэй засаглалыг бий болгоход дэмжлэг үзүүлж ажиллана.”</b>				
1	Банкны эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдал, эрсдэлийн тайлангийн чанар болон комплайнсын хэрэгжилтэд дотоод аудит хэрхэн хяналт тавьдаг вэ?	2	2	
2	Журмын 6.1-д заасны дагуу ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад тайлагнаж буй эрсдэлийн тайлангийн чанар, комплайнсын хэрэгжилт, дотоод хяналтын тогтолцоог тогтмол бие даан үнэлж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг хараат бус бодит нотлох баримтаар хангаж чаддаг уу?	2	2	



3	Хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгон шалгаруулахдаа ямар шалгуур үзүүлэлтийг ашигладаг вэ? Сонгох явцад ТУЗ-ийн хараат бус гишүүд хэрхэн оролцдог вэ?	2	2	
4	Хөндлөнгийн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авсан бэ? Хамгийн сүүлд аудитын дүгнэлтийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар танилцуулна уу.	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>8</b>	<b>8</b>	

#### Зарчим 11. Цалин, урамшуулал

**“Банкны цалин урамшууллын тогтолцоо нь сайн гүйцэтгэл болон эрсдэлийн удирдлагын зарчимтай нийцтэй байна.”**

1	ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тогтоох шалгуур үзүүлэлтүүд юу вэ?	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>2</b>	<b>2</b>	

#### Зарчим 12. Тайлагнал ба ил тод байдал

**“Банкны цалин урамшуулал, сонирхлын зөрчилтэй хэлцэл болон бусад эрсдэл учруулж болох үйл ажиллагаа, мэдээ мэдэгдэл, материаллаг өөрчлөлтүүд нь хувьцаа эзэмшигч, халгаламж эзэмшигч болон холбогдох бусад оролцогч талуудад ил тод байх ба**

1	Журмын 7.1-д заасан мэдээллийг олон нийтэд мэдээлж, тайлагнасан эсэх?	2	2	
2	Холбогдох этгээдтэй хийсэн гэрээ, хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахдаа зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг үндэслэлтэй тогтоосон эсэх?	2	2	
3	Банк нь эрсдэлийн удирдлагын стратеги, анхаарал хандуулах	2	2	
<b>Нийт дүн:</b>		<b>6</b>	<b>6</b>	

#### Зарчим 13. Зохицуулагч байгууллагын үүрэг, хариуцлага

**“Зохицуулагч байгууллагууд нь зохистой засаглалын зарчмыг банканд удирдан чиглүүлэх, хяналт тавих ба ТУЗ болон гүйцэтгэх удирдлагатай энэ талаар тогтмол харилцаж, үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба зохистой засаглалын талаарх мэдээллийг хуваалцаж ажиллана.”**

1	Банк хариуцсан хянан шалгагчийн зүгээс банкны засаглалд цогц үнэлгээ хийж, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад засаж сайжруулах шаардлага хүргүүлдэг үү? Хянан шалгагчийн зүгээс банкны засаглалыг сайжруулах үүднээс хамгийн сүүлд ямар шаардлага тавьсан бэ? Банкны зүгээс хянан шалгагчийн шаардлагыг хэрхэн биелүүлсэн бэ?	2	2	
<b>Нэгдсэн дүн</b>		<b>100</b>	<b>100</b>	

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Банкны үнэлгээ	Зөрүү
1	<b>Зарчим 1.</b> ТУЗ-ийн үүрэг хариуцлага	14	14	-
2	<b>Зарчим 2.</b> ТУЗ-ийн мэргэшсэн бүрэлдэхүүн	8	8	-
3	<b>Зарчим 3.</b> ТУЗ-ийн бүтэц, үйл ажиллагааны зарчим	24	24	-
4	<b>Зарчим 4.</b> Гүйцэтгэх удирдлага	10	10	-
5	<b>Зарчим 5.</b> Нэгдлийн засаглал	4	4	-

6	<b>Зарчим 6.</b> Эрсдэлийн удирдлага	8	8	-
7	<b>Зарчим 7.</b> Эрсдэлийг үнэлж, хянах	4	4	-
8	<b>Зарчим 8.</b> Эрсдэлийн мэдээлэл, солилцоо	2	2	-
9	<b>Зарчим 9.</b> Комплайнс буюу нийцлийн үйл ажиллагаа	8	8	-
10	<b>Зарчим 10.</b> Дотоод аудит ба хөндлөнгийн аудит	8	8	-
11	<b>Зарчим 11.</b> Цалин урамшуулал	2	2	-
12	<b>Зарчим 12.</b> Тайлагнал ба ил тод байдал	6	6	-
13	<b>Зарчим 13.</b> Зохицуулагч байгууллагын үүрэг, хариуцлага	2	2	-
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>100</b>	<b>100</b>	-

Үнэлгээ

.....

Нэгдсэн үнэлгээ 80 оноогоос дээш байвал сайн засаглалтай буюу банкны удирдлагын үйл ажиллагаа хэвийн;	Сайн	80-аас дээш
Нэгдсэн үнэлгээ 65-79 оноо байвал дунд засаглалтай буюу банкны удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсч болзошгүй;	Дунд	65-79
Нэгдсэн үнэлгээ 50-64 оноо байвал хангалтгүй засаглалтай буюу банкинд хяналт шалгалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн;	Хангалтгүй	50-64
Нэгдсэн үнэлгээ 49 оноогоос доош байвал муу засаглалтай банк буюу банкны удирдлагын үйл ажиллагаанд албадлагын арга хэмжээ авах үндэслэл болно.	Муу	49-оос доош